



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

“Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний
аргачлал” /БД 25-102-24/ барилгын
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,
Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасныг тус тус үндэслэн
ТУШААХ нь:

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 03-5/2024 дугаар шийдвэрийн дагуу “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал” /БД 25-102-24/ барилгын дүрмийг хавсралт ёсоор баталж, 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зөвлөмжийн шинж чанартай мөрдсүгэй.
2. “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал” /БД 25-102-24/ барилгын дүрмийг мөрдөж эхлэхээс өмнө хэвлэн олшруулж, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ (Т.Пүрэвхатан)-т даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар (Д.Гантулга)-т даалгасугай.



Ж.БАТСУУРЬ

1524010272

НОГООН БАРИЛГЫН ҮНЭЛГЭЭ (BESTGER)-НИЙ АРГАЧЛАЛ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдахаар төлөвлөгдсөн болон баригдсан бүх төрлийн орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгад ногоон барилгын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, түүний дагуу зэрэглэл тогтооход хэрэглэнэ.
- 1.2 Энэхүү аргачлалыг 1.1-д заасан бүх төрлийн барилгыг төлөвлөх, барих, ашиглах үйл ажиллагаанд хэрэглэж болно.

2. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 2.1 Энэхүү аргачлалын зорилго нь барилгын салбараас ялгарах хүлэмжийн хий болон агаар орчны бохирдлыг бууруулсан, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвартай, иргэдийн эрүүл, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлсэн барилгыг онооны системээр үнэлж, зэрэглэл тогтооход оршино.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

- 3.1 Энэхүү аргачлалд А хавсралтад заасан норм, нормативын баримт бичгүүдийг ашигласан болно.
- 3.2 Аргачлал батлагдсанаас хойш ишлэл авсан баримт бичигт нэмэлт, өөрчлөлт хийсэн, шинэчилсэн байвал тэдгээр нэмэлт, өөрчлөлт хийсэн болон шинэчилсэн баримт бичгийг мөрдөнө.

4. НЭРШИЛ

- 4.1 Ногоон барилгын үнэлгээний аргачлалыг боловсруулахад олон улсад түгээмэл хэрэглэгддэг Америкийн Нэгдсэн Улсын LEED, Англи улсын BREEAM, Герман улсын DGNB, Оросын Холбооны Улсын ЗЕЛЕНЫЙ, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн EDGE үнэлгээний системүүдийг үндэслэл болгон харьцуулж, Монгол улсын **онцлогтой** уялдуулан дараах зарчмыг баримталж нэршлийг тодорхойлсон. Үүнд:

Эрчим хүч, ус болон бусад байгалийн нөөцөд хэмнэлттэй байх
Тэсвэртэй байх; (үүнд: газар хөдлөлт, гал, үер ус, барилгын насжилт)
Санхүүгийн боломжид нийцсэн, хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх;
Олон улсын жишигт нийцсэн байх.

- 4.2 Ногоон барилгын үнэлгээний системийн нэршлийг “BestGER” гэж нэрлэсэн.

Тайлбар: Монгол Улсын үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг олон улсад таниулах зорилгоор “Best Governance in Efficiency and Resilience” гэх үгсийг, Монголын уламжлалт сууц монгол гэрийн нэршлийг шингээж байхаар “BestGER” гэсэн товчлолыг сонгосон.

Утга агуулга:

- Барилгын технологийн болон ногоон санхүүгийн хамгийн оновчтой шийдлийг шингээсэн барилга байх үүднээс **Best** гэх;
- Ногоон барилгын олон талт асуудлыг цогцоор нь зохицуулах, үнэлэх зэрэглэл тул **Governance** гэх;
- Эрчим хүч ба усны хэмнэлт, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулж байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр өгөөжтэй ашиглах тул **Efficiency** гэх;
- Газар хөдлөлт, гал, үер усны аюулын эрсдэлээс хамгаалагдсан бат, бэх мөн эрс тэс уур амьсгалд тэсвэртэй байх агуулгаар **Resilience** гэж тусгасан.

5. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫН ТӨРӨЛ, ЗЭРЭГЛЭЛ

5.1 Ногоон барилгын “BestGER” үнэлгээний аргачлал нь дэлгэрэнгүй, хялбаршуулсан гэсэн төрөлтэй байна.

5.2 Дэлгэрэнгүй үнэлгээний “BestGER” аргачлал нь Барилгын тухай хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан барилгыг ногоон барилгын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлэхэд ашиглагдана.

Дэлгэрэнгүй “BestGER” үнэлгээний аргачлалаар тогтоох ногоон барилгын зэрэглэл нь нийт 6 бүлэг, 31 шалгуур үзүүлэлттэй бөгөөд дараах байдлаар 100 хүртэл оноотой. Үүнд:

- 1) 91-100 оноог A+
- 2) 81-90 оноог A
- 3) 71-80 оноог B+
- 4) 61-70 оноог B
- 5) 50-60 оноо суурь гэрчилгээ олгоно.

5.3 Хялбаршуулсан үнэлгээний “BestGER” аргачлалаар Барилгын тухай хуулийн 10.1.1-д заасан барилгын ногоон барилгын шалгуур үзүүлэлтүүдийг дагуу үнэлэхэд ашиглагдана.

5.4 Хялбаршуулсан үнэлгээний “BestGER” аргачлалаар тогтоох ногоон барилгын зэрэглэл нь нийт 2 бүлэг, 12 шалгуур үзүүлэлттэй бөгөөд дараах байдлаар 100 хүртэл оноотой. Үүнд:

- 1) 81-100 оноог A
- 2) 61-80 оноог B
- 3) 40 – 60 оноо суурь гэрчилгээ олгоно.

5.5 Барилгын зураг төсөл төлөвлөлтийн үе шатанд хамаарах шалгуур үзүүлэлтүүдийг “Төлөвлөх - Т”, барьж байгуулах үе шатанд хамаарах шалгуур үзүүлэлтүүдийг “Барих - Б”, ашиглалтын үе шатанд хамаарах шалгуур үзүүлэлтүүдийг “Ашиглах - А” гэж тус тус тэмдэглэсэн.

5.6 Заавал биелүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг 3 (Заавал) гэж тэмдэглэсэн ба хаалт доторх тоо заавал авах босго оноо байна.

6. НОГООН БАРИЛГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

6.1 НОГООН БАРИЛГЫН “ДЭЛГЭРЭНГҮЙ” ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ хийх үе шат	Боломжит оноо
Бүлэг 1. Хүрээлэн буй орчин. (Боломжит оноо 10)			
1	Нийтэд хүртээмжтэй байдал 3 (2)	Т	2
2	Ногоон байгууламж	Т	2
3	Ногоон тээврийн хэрэгслийн зогсоол	Т	1
4	Хог хаягдлын ангилалт	Т, А	1
5	Нийтийн тээврийн зогсоолд ойр байршил	Т	1
6	Гадна орчны гэрэлтүүлэг	Т, А	1
7	Төлөвлөлт ба хамтын ажиллагаа	Т, Б, А	2
Бүлэг 2. Эрчим хүчний хэмнэлт (Боломжит оноо 35)			
8	Дулааны эрчим хүчний хэмнэлт 3 (8)	Т, Б, А	25
9	Цахилгаан эрчим хүчний хэмнэлт	Т, Б, А	4
10	Сэргээгдэх эрчим хүч	Т, А	3
11	Автоматжуулалт ба мэдрэгч	Т, А	2
12	Гэрэлтүүлэг	Т, А	1
Бүлэг 3. Материал болон нөөц ашиглалт. (Боломжит оноо 10)			
13	Хэрэглэсэн материалд шингэсэн эрчим хүч	Т, Б	5
14	Дахивар ашигласан байдал	Т, Б	3
15	Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материал	Т, Б, А	2

Бүлэг 4. Усны хэмнэлт. (Боломжит оноо 18)			
16	Цэвэр усны хэмнэлт 3 (2)	Т, А	8
17	Саарал ус ашиглалт	Т, Б	5
18	Усны ухаалаг хэрэглээ	Т, Б	3
19	Тоолуур ашиглалт	Т, А	2
Бүлэг 5. Тэсвэржилт. (Боломжит оноо 15)			
20	Газар хөдлөлт тэсвэрлэлт 3 (3)	Т, Б	5
21	Аюулгүйн гарц, галын шат	Т, А	1
22	Эдэлгээ өндөртэй материал ашиглалт	Т, Б	2
23	Үерийн хамгаалалт	Т, Б	2
24	Хур тунадас зайлуулах шугам	Т, Б	2
25	Барилгын насжилт	Т, Б	3
Бүлэг 6. Дотоод орчны чанар. Боломжит оноо 12			
26	Агаарын чанар 3 (3)	Т, А	3
27	Нийтэд хүртээмжтэй байдал 3 (2)	Т, А	3
28	Агаарын урсгал (үр ашигтай агаар сэлгэлт)	Т, А	2
29	Дуу чимээний тусгаарлалт ба акустик	Т, Б	2
30	Байгалийн гэрэл	Т	1
31	Чийгшил	Т, А	1
	Нийт оноо 3 (20)		100

Тайлбар: 3 (заавал) – урьдчилсан гэрчилгээ авахад заавал биелүүлэх шалгуур үзүүлэлт
Т – төлөвлөлтийн үе шат, Б – барьж байгуулах үе шат, А – ашиглалтын үе шат

6.2 НОГООН БАРИЛГЫН “ХЯЛБАРШУУЛСАН” ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 2.

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ хийх үе шат	Боломжит оноо
Бүлэг 1. Эрчим хүч, усны хэмнэлт. Боломжит оноо 60			
1	Эрчим хүчний хэмнэлт 3 (11)	Т, Б, А	35
2	Усны хэмнэлт 3 (1)	Т, А	13
3	Саарал усны хэрэглээ	Т, А	5
4	Материалын сонголт	Б	5
5	Төлөвлөлт ба хамтын ажиллагаа	Т, А	2
Бүлэг 2. Тэсвэржилт ба Хүрээлэн буй орчин. Боломжит оноо 40			
6	Бүтээцийн бат бэх байдал 3 (2)	Т, Б	5
7	Газар хөдлөлтөд тэсвэртэй байдал 3 (3)	Т, Б	5
8	Тав тухтай байдал	Т, А	5
9	Үерийн хамгаалалт, галын аюулгүй байдал	Т, Б	5
10	Дотор агаарын чанар 3 (3)	Т, А	5
11	Хүртээмж	Т	5
12	Хүрээлэн буй орчин	Т, Б	10
	Нийт боломжит оноо 3 (20)		100

3 (заавал) – урьдчилсан гэрчилгээ авахад заавал биелүүлэх шалгуур үзүүлэлт

**7. ДЭЛГЭРЭНГҮЙ “BESTGER” ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ТОДОРХОЙЛОЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, ХОЛБОГДОХ
БАРИЛГЫН НОРМ, ДҮРЭМ, СТАНДАРТ**

7.1 Бүлэг 1 Хүрээлэн буй орчин - 7 шалгуур үзүүлэлт, 10 оноотой

Энэ бүлэгт барилга байгууламжийн гадна орчин, хаалга, орц гарцын нийтэд хүртээмжтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, ахмад настанд ээлтэй байдал, ногоон тээврийн хэрэгслийн болон унадаг дугуй, скүүтерийн зогсоол, нийтийн тээврийн зогсоол, хог хаягдлын зохистой менежмент, орчны эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтүүд багтсан. Эдгээрийг Хүснэгт 3-т заасан аргачлалын дагуу дүгнэнэ.

Заавал биелүүлэх шалгуур үзүүлэлт доор хүснэгтийн 1.1 болно.

Хүснэгт 3.

Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах аргачлал	Холбогдох барилгын норм, дүрэм, стандарт
БҮЛЭГ 1. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН	
Шалгуур үзүүлэлт 1.1 Нийтэд хүртээмжтэй байдал - 2 оноо 3	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн гадна орчныг нийтэд хүртээмжтэй, орц гарцыг бүх хүнд хялбар байлгах <i>Төлөвлөх</i>	
Барилга байгууламжийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандусыг холбогдох норм, дүрэм, стандартад нийцүүлэн хүртээмжтэй зураг төсөл боловсруулсан байх. - 1 оноо (3)	“Барилга,байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” БНБД 35- 01-22 MNS 6055:2009, MNS 6056:2009
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тээврийн хэрэгслийн авто зогсоолтой байх, барилгын гадна болон хашааны хаалга хүүхдийн тэрэг, тэргэнцэр орж гарахад саадгүй байх - 1 оноо (3)	MNS 6055: 2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. үндсэн шаардлага

Шалгуур үзүүлэлт 1.2 Ногоон байгууламж - 2 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгын гадна орчныг хүн, байгальд ээлтэй шийдлээр тохижуулах	
<i>Төлөвлөх</i>	
Барилгын эдэлбэр газрын 20 хувийг ногоон байгууламж эзлэсэн байх 1 оноо	“Барилгын орчны Тохижилтын ажил” /БНБД 3.01.06-90/
Барилгын гадна талбайн 10-20 хувийг усалгаа бага шаардах ургамлын бүрхэвч бүхий ногоон байгууламжтай байхаар тохижуулсан байх-1 оноо	
Шалгуур үзүүлэлт 1.3 Ногоон тээврийн хэрэгслийн зогсоол - 1 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Хүлэмжийн хийн ялгаралгүй тээврийн хэрэгслийг ногоон тээвэр гэх бөгөөд энэхүү тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжих	
<i>Төлөвлөх</i>	
Цахилгаан тээврийн хэрэгслийн цэнэглэгчтэй зогсоолыг төлөвлөх ба тоо хэмжээ нь нийт зогсоолын 2 хувиас багагүй байх-1 оноо	“Авто зогсоол” /БНБД 21-05-10/
эсвэл	
Унадаг дугуй, скүүтэрийн зогсоол барилгын хэмжээнээс хамаарсан зогсоолтой байх -1 оноо	
Шалгуур үзүүлэлт 1.4 Хог хаягдлын ангилалт - 1 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга, байгууламжийн орчны цэвэр байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах	
<i>Төлөвлөх, ашиглах</i>	

<p>Хог хаягдлын ангиллыг хамгийн багадаа цаас, шил, хуванцар болон хүнсний хаягдлыг ангилдаг байхаар төлөвлөсөн, ангилсан хог хаягдлыг хадгалах, агуулах байгууламжтай байх-1 оноо.</p> <p>эсвэл,</p> <p>Тухайн барилга дахивар хүлээж авах болон ангилах зориулалтын өрөө эсвэл газартай байхаар тусгаж, дахиврыг дахин боловсруулдаг үйлдвэртэй гэрээлэн нийлүүлдэг байх - 1 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлт 1.5 Нийтийн тээврийн зогсоолд ойр байршил - 1 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Оршин суугчдын нийтийн тээврийн хэрэгслийн үр ашигтай хэрэглээг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах</p> <p><i>Төлөвлөх</i></p>	
<p>Барилгаас 800 метрийн тойрогт нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолтой байх эсхүл нийтийн тээврийн зогсоол төлөвлөгдсөн байх, ашиглах боломжтой байх - 1 оноо</p>	<p>Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөгдсөн байршилд байх, “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” /БД 32- 101-17/</p>
<p>Шалгуур үзүүлэлт 1.6 Гадна орчны гэрэлтүүлэг - 1 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Оршин суугчдын зорчих тав тух, аюулгүй байдлыг сайжруулах</p> <p><i>Төлөвлөх, ашиглах</i></p>	
<p>Гадна гэрэлтүүлэг нь хэрэглэгч болон оршин суугчдад ая тухтай байх, шөнийн цагаар барилгын гадна орчинд зорчиход хангалттай гэрэлтүүлж байх -1 оноо</p>	<p>“Орон сууц, олон нийтийн барилгын гэрэлтүүлэг” /БНБД 81-20-04/</p> <p>“Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг” /БНБД 23-02-08/</p>
<p>Шалгуур үзүүлэлт 6.7 Төлөвлөлт ба хамтын ажиллагаа - 2 оноо</p>	

Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгын ашиглалт дуустал бүх хугацаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг нэгдмэл байлгах, төлөвлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэх	
<i>Төлөвлөх, барих, ашиглах</i>	
Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, захиалагч, худалдан авагч, өмчлөгч, ашиглагч, түрээслэгч, ашиглалт үйлчилгээ хариуцагч нарын ногоон барилгын тогтвортой зорилгын төлөөх хамтын ажиллагааг аль болох хангасан байх – 1 оноо	
Талуудын хамтын ажиллагаа, үүнд ашиглагч, оршин суугчдын хандлагад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөсөн байх - 1 оноо	

7.2 Бүлэг 2: Эрчим хүчний хэмнэлт - 5 шалгуур үзүүлэлт, 35 оноотой

Энэ бүлэгт цахилгаан болон дулааны хэмнэлтийг автоматжуулалт, мэдрэгч, тоолуур, ухаалаг хэрэглээ ашиглан бий болгосон, мөн сэргээгдэх эрчим хүч ашигласан байдлыг Хүснэгт 4-т заасан аргачлалын дагуу дүгнэнэ.

Хүснэгт 4.

Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах аргачлал	Холбогдох норм, дүрэм, стандарт
БҮЛЭГ 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	
Шалгуур үзүүлэлт 2.1 Дулааны хэмнэлт 25 оноо 3	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн дулааны хэрэглээ, зарцуулалтыг бууруулах замаар эрчим хүчний үр ашгийг сайжруулах	
<i>Төлөвлөх, Барих, Ашиглах</i>	
Барилгын эрчим хүчний хэрэгцээний хувийн тооцооны үзүүлэлт нь нормчилсон үзүүлэлтээс 1) 80-аас дээш хувиар хэмнэсэн бол 18 оноо 2) 60 - 80 хувь хэмнэсэн бол 15 оноо 3) 35 - 60 хувь хэмнэсэн бол 13 оноо 4) 10 - 35 хувь хэмнэсэн бол 11 оноо (M)	“Барилгын дулаан хамгаалалт” /БНБД 25- 01-20/
Барилгын нийт эрчим хүчний хэрэгцээг БНБД 25-01-20 үндэслэн тооцоолно.	

<p>Агаар сэлгэлтийн систем – 3 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>а) Агаар сэлгэлтийн систем нь эрүүл ахуйн шаардлагыг зөвшөөрөгдөх хязгаарт автоматаар тохируулж хангахаар төлөвлөсөн бол -1 оноо.</p> <p>б) Агаар сэлгэлтийн систем нь эрүүл ахуйн шаардлагыг зохистой хязгаарт автоматаар тохируулж хангахаар төлөвлөсөн бол -2 оноо</p> <p>с) Агаар сэлгэлтийн системд хаягдал дулаан ашиглах систем төлөвлөсөн бол (ERV, HRV) -3 оноо</p>	<p>“Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер” БНБД 41-01-11</p>
<p>Халаалтын систем – 2 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>а) Халаалтын систем нь байрны удирдлагатай тохируулах термостат, баланслагч хаалттай тохируулгыг барилгыг нийтэд нь эрүүл ахуйн шаардлага хангахаар ДХТөв, Холих насосны узелтэй төлөвлөсөн бол – 1 оноо</p> <p>б) Халаалтын систем нь автоматаар тохируулах термостат, баланслагч хаалттай тохируулга нь нэг барилгын төрөл бүрийн зориулалттай өрөө тасалгаагаар нь эрүүл ахуйн шаардлага хангахаар холих насосны узел төлөвлөсөн бол – 2 оноо</p>	<p>“Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер” БНБД 41-01-11</p>
<p>Дулааны тоолуур - 2 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>а) Дулааны тоолуурыг ДХТөв, Холих насосны узель дээр төлөвлөсөн бол -1 оноо</p> <p>б) Дулааны тоолуурыг сууц (өрх) бүрийн халаалтын систем дээр төлөвлөсөн бол - 2 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлт 2.2 Цахилгааны хэмнэлт - 4 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн цахилгааны хэрэглээтэй холбоотой эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах</p> <p><i>Төлөвлөлт, барих, ашиглах</i></p>	
<p>Эрчим хүчийг (ЭХ) үр ашигтай түгээх систем – 2 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>а) ЭХ-ний үр ашигтай ачааны болон зорчигчийн лифт суурилуулсан бол – 1 оноо</p> <p>б) Цахилгаан эрчим хүч (ЦЭХ) хэмнэх регенератив ашигласан бол – 1 оноо</p>	

<p>Дулаан хуваарилах төвийн систем – 2 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>a. Дулаан хангамжийн системийн сүлжээний насос нь хувьсах зарцуулалтын насостой бол – 1 оноо</p> <p>b. Дулааны эх үүсвэр нь дулааны насостой хосолсон бол – 2 оноо</p>	<p>“Дулааны сүлжээ” БНБД 41-02-13</p>
--	---

<p>Шалгуур үзүүлэлт 2.3 Сэргээгдэх эрчим хүч - 3 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн ЦЭХ-ний хэрэгцээг хангахын тулд СЭХ ашиглах болон ЦЭХ-ний хэрэглээ багатай үед хуримтлуулсан ЭХ-ийг хэрэглээ өндөртэй үед ашиглах замаар төвлөрсөн сүлжээний ЦЭХ-ний ачааллыг багасгах</p> <p><i>Төлөвлөх, Ашиглах</i></p>	
<p>Сэргээгдэх эрчим хүчний нөөц – 3 оноо</p> <p>СЭХ-ний бүх төрлийн эх үүсвэрийг ашиглан барилгын нийт ЦЭХ-ний хэрэглээний хэдэн хувийг хааж байгаагаар тооцно. Үүнд</p> <p>a. 30-аас дээш хувь бол - 3 оноо</p> <p>b. 15 - 30 хувь бол - 2 оноо</p> <p>c. 15 аас бага хувь бол - 1 оноо</p> <p>Барилгын нийт эрчим хүчний хэрэглээг ЭХХ-ний гэрчилгээнд үндэслэх эсвэл эрчим хүчний симуляцийн програм хангамжаар тооцож гаргана.</p>	<p>Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ, хүчинтэй хугацааг харгалзана.</p> <p>MNS 4674:1998 Нарны зайн систем хүчин чадлыг тооцох аргачлал</p>
<p>Шалгуур үзүүлэлт 2.4 Автоматжуулалт - 2 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн цахилгааны хэрэглээг автоматжуулах болон мэдрэгч ашиглах замаар уян хатан хэрэглээг дээшлүүлэх, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх</p> <p><i>Төлөвлөлт, ашиглах</i></p>	
<p>Автоматжуулалтын систем – 2 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>a. Гэрийн ухаалаг систем ашигласан (<i>резетка, гэрэл, ус мэдрэгч, утаа мэдрэгч, хөдөлгөөн мэдрэгч</i>) бол – 2 оноо</p> <p>b. Халаах хэрэгсэл нь өрөөний температураас хамаарч ажилладаг тохируулах хаалт буюу термостаттай бол – 2 оноо</p>	<p>MNS 6241:2011 Дулааны тоолуур. Суурилуулалт ашиглалтанд оруулах, ажиллагааг хянах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлага</p> <p>“Автоматжуулалтын систем” /БНБД 3.05.07-</p>

<p>c. ДХАС¹, УХАТ, Цахилгаан хангамж, Гал түймрээс хамгаалах /Эсвэл инженерийн хангамжийн/ системүүд нь нэгдсэн хяналт, удирдлагын системтэй бол - 2 оноо</p> <p>d. Ухаалаг тоолууртай бол – 1 оноо</p> <p>e. Хэрэглэгч/тасалгаа бүрийн гэрэлтүүлэг удирдлагатай бол - 1 оноо</p>	90/
<p>Шалгуур үзүүлэлт 2.5 Гэрэлтүүлэг - 1 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжид ашиглаж байгаа гэрэлтүүлэгт техникийн шийдлээр цахилгааны хэмнэлт бий болгох</p> <p><i>Төлөвлөлт, ашиглах</i></p>	
<p>Гэрэлтүүлэг – 1 оноо</p> <p>Дараах хувилбаруудаас сонголтоор:</p> <p>a. Ашиглаж байгаа бүх гэрэлтүүлэгчийн 80-аас доошгүй хувь LED бол - 1 оноо</p> <p>b. Барилгын дотор, гадна орчинд суурилуулсан гэрэлтүүлэгчийн 50-иас доошгүй хувь хөдөлгөөн мэдрэгчтэй эсвэл цагийн тавилттай эсвэл гэрэл бууруулагчтай бол – 1 оноо</p>	<p>“Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг” /БНБД 23- 02-08/</p> <p>“Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах” / БД 43-102-07/</p>

7.3 Бүлэг 3: Материал болон нөөц ашиглалт - 3 шалгуур үзүүлэлт, 10 оноотой

Энэ бүлэгт барилгын материал үйлдвэрлэх болон тээвэрлэх явцад шингэсэн эрчим хүчийг бууруулж, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, материалыг дахин ашиглах, эрүүл мэндэд хортой бодис агуулаагүй барилгын материал ашигласан байдлын үнэлгээ болон барилгын насжилтыг уртасгах зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд багтана.

Эдгээрийг Хүснэгт 5-д заасан аргачлалын дагуу дүгнэнэ.

Хүснэгт 5.

<p>Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах аргачлал</p>	<p>Холбогдох норм, дүрэм, стандарт</p>
<p>БҮЛЭГ 3. МАТЕРИАЛ БОЛОН НӨӨЦ АШИГЛАЛТ</p>	
<p>Шалгуур үзүүлэлт 3.1 Хэрэглэсэн материалд шингэсэн энерги - 5 оноо</p>	

¹ ДХАС- дулаан хадгалалт, агаар сэлгэлтийн систем

<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгад ашиглах барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглах, суурилуулах явц дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шаардагдах шингэсэн эрчим хүчийг хэмнэх</p> <p><i>Төлөвлөх, барих</i></p>	
<p>Барилгад шингэсэн эрчим хүч багатай материал сонгосон бол - 2 оноо</p> <p>Үүнд: Барилгад ашигласан материалын 25 хувиас дээш нь шингэсэн эрчим хүч багатай материал бол - 2 оноо</p> <p>Барилгад ашигласан материалын 2-25 хувь нь шингэсэн эрчим хүч багатай материал бол - 1 оноо</p>	<p>Барилгын бүтээц ба эдлэхүүний норматив бичгүүд, БНБД 51-02-05, БНБД 52-01-10, БНБД 52-02-05, БНБД 52-03-05, БНБД 52-04-12</p>
<p>Орон нутагт үйлдвэрлэсэн материал барилга угсралтад ашигласан материалын 20-оос дээш хувийг эзэлсэн бол - 2 оноо</p>	
<p>Барилгын материалыг үйлдвэрлэхдээ хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй байсныг батлах тохирлын гэрчилгээтэй байх (<i>хамгийн багадаа нийт материалын 20 хувь</i>) – 1 оноо</p>	<p>Тохирлын гэрчилгээ, экспорт, импортын барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизм, түүхий эдийн бүртгэлийн "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн бүртгэлийг үндэслэх</p>
<p>Бүтээц эдлэлийн эзлэхүүний 10-аас дээш хувьд дахин ашиглах боломжтой материал ашигласан бол – 1 оноо</p>	<p>"Нийтийн зориулалттай нийт талбай нь 1000м²-аас дээш орон сууцны барилгын ажилд шаардагдах гол нэр төрлийн барилгын материалын орц" /БД 82-104-10/</p>

Шалгуур үзүүлэлт 3.2 Дахивар ашигласан байдал - 2 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгад дахин боловсруулсан материал, бүтээгдэхүүн ашиглахыг дэмжиж, байгалийн нөөцийг хэмнэх <i>Төлөвлөх, барих</i>	
Барилга угсралтын ажилд нийт ашиглагдах материалд үндсэн техникийн үзүүлэлт хангасан хуучин барилгын материал дахин ашиглахаар төлөвлөсөн бол – 1 оноо	
Сэргээгдэх боломжтой түүхий эд, органик материал нийт материалын эзэлхүүний 10-аас дээш хувь эзлэх бол 1 оноо	
Шалгуур үзүүлэлт 3.3 Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материал ашиглалт - 3 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга, байгууламжид хүн, амьтанд хоргүй бодис, барилгын материал, бүтээгдэхүүн ашигласан байдлыг дэмжих <i>Төлөвлөх, барих, ашиглах</i>	
Хорт бодисын агууламжгүй, эко шошготой эсвэл био задрах боломжтой материал ашигласан бол - 1 оноо	Гарал үүслийн гэрчилгээг үндэслэх
Дотор заслын материал эрүүл ахуйн гэрчилгээний дагуу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бол - 2 оноо	“Заслын ажил” /БНБД 31- 10-05/

7.4 Бүлэг 4: Усны хэмнэлт - 4 шалгуур үзүүлэлттэй, 18 оноотой

Энэ бүлэгт цэвэр усны хэмнэлт, усны ухаалаг хэрэглээ, хэмнэлттэй тоноглол ашиглалт, саарал усны ашиглалт, хур тунадасны усыг хуримтлуулах, эргүүлэн ашиглах, хаягдал ус цэвэрлэх технологи, инноваци ашиглалтыг Хүснэгт 6-д заасан аргачлалын дагуу дүгнэнэ. Заавал биелүүлэх шалгуур үзүүлэлт цэвэр усны хэмнэлт буюу 4.1 байна.

Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах аргачлал	Холбогдох барилгын норм, дүрэм, стандарт
БҮЛЭГ 4. УСНЫ ХЭМНЭЛТ	
Шалгуур үзүүлэлт 4.1 Цэвэр усны хэмнэлт - 8 оноо М	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжид ашиглах цэвэр усыг хэмнэж, усны хэрэглээг бууруулах <i>Ашиглах,</i>	
Нэг оршин суугчийн хоногт хэрэглэх усны хэмнэсэн хувиар 8 хүртэл оноо Үүнд: 1) 20 - хувь хэмнэсэн бол – 2 оноо (М) 2) 21- 30 хувь хэмнэсэн бол – 3 оноо 3) 31- 40 хувь хэмнэсэн бол – 4 оноо 4) 41- 50 хувь хэмнэсэн бол – 5 оноо 5) 51- 60 хувь хэмнэсэн бол – 6 оноо 6) 61-70 хувь хэмнэсэн бол – 7 оноо 7) 71-ээс дээш хувь хэмнэсэн бол – 8 оноо	“Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж” /БНБД 40- 02-16/
Шалгуур үзүүлэлт 4.2 Саарал ус ашиглалт - 4 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга, байгууламжид саарал ус ашиглан цэвэр усны хэрэглээг бууруулах <i>Төлөвлөх, ашиглах</i>	
Саарал ус ашиглалт – 4 оноо Дараах хувилбаруулаас сонголтоор: а. Барилгад бүхэлд нь ашиглах саарал усны системтэй бол - 4 оноо б. Барилга хэсэгчилсэн байдлаар ашиглах саарал усны системтэй бол - 3 оноо с. Саарал усыг эргүүлэн ашиглах зориулалттай дэвшилтэт шийдэл ашигласан бол - 2 оноо	MNS BS 8525-1:2015 Саарал усны систем

Шалгуур үзүүлэлт 4.3 Усны ухаалаг хэрэглээ - 5 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжид тоноглолоор усны хэмнэлт бий болгох <i>Төлөвлөх, ашиглах</i>	
Усны хэмнэлттэй тоноглол суурилуулсан бол – 2 оноо	
Усны системийн даралтын тохируулгыг хангасан инженерийн шийдэлтэй бол - 1 оноо	
Гадна талбайд хурын усыг ногоон байгууламжинд авч үлдэх төлөвлөлтийн шийдэлтэй бол - 2 оноо	Хурын ус дахин ашиглах стандарт
Шалгуур үзүүлэлт 4.4 Тоолуур ашиглалт - 1 оноо	
Шалгуур үзүүлэлтийн зорилго: Хэрэглэгчийн усны хэрэглээний мэдлэгийг нэмэгдүүлэх, хэмжих <i>Төлөвлөх, ашиглах</i>	
Усны тоолуур нь алсын зайнаас мэдээлэл дамжуулах, өгөгдлийг нэг жилээс дээш хугацаанд хадгалж дүн шинжилгээ хийх боломжтой байх – 1 оноо	MNS EN 806-2: 2021 Барилга доторх унд-ахуйн ус хангамжийн системд тавих техникийн шаардлага. 2-р хэсэг: Зураг төсөл

7.5 Бүлэг 5: Тэсвэржилт - 6 шалгуур үзүүлэлт, 15 оноотой

Энэ бүлэгт барилгын газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшигт тэсвэртэй байдлыг үнэлэхийн зэрэгцээ галын аюулд тэсвэртэй байдал, зэвэрдэггүй болон шатдаггүй материал сонголтыг дэмжих, барилгын эдэлгээг уртасгах шалгуур үзүүлэлтүүд орсон бөгөөд хэрэв хуучин барилгыг засварлан, ногоон барилга болгохоор ретрофит хийх бол барилга баригдах үед батлагдаагүй байсан газар хөдлөлтийн хүчитгэлийг нэмэх, шинэ технологи материал ашиглан галын эрсдэл бууруулах зэргээр эрсдэл багасгах алхамуудыг дэмжих зорилготой шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан.

Эдгээрийг Хүснэгт 7-д заасан аргачлалын дагуу дүгнэнэ.

Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах аргачлал	Холбогдох норм, дүрэм, стандарт
БҮЛЭГ 5. ТЭСВЭРЖИЛТ	
Шалгуур үзүүлэлт 5.1 Газар хөдлөлт тэсвэрлэлт - 5 оноо (3)	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгын газар хөдлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулах, хүчитгэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх</p> <p><i>Төлөвлөх, барих</i></p>	
Газар хөдлөлт тэсвэрлэлтийг тооцож төлөвлөсөн байх: 3 оноо (М)	Газар хөдлөлтийн бүс нутаг дахь орон сууцны барилгын давхрын тоо ба нийт уртыг БНБД 22-01-21*/22 ашиглан тодорхойлох
<p>Бүтээцийн статик болон динамик тооцоогоор газар хөдлөлт тэсвэрлэлт хангалттай гэж гарсан бол - 1 оноо эсвэл</p> <p>Барилгын үндсэн бүтээцийн бат бэх байдлыг үл эвдэх сорилын аргаар хэмжилт хийлгэн, баталгаажуулсан байх - 1 оноо</p>	
Шалгуур үзүүлэлт 5.2 Аюулгүйн гарц, галын шат - 1 оноо	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн галын эрсдлийг бууруулах, оршин суугчдын хамтын хандлагыг сайжруулах</p> <p><i>Төлөвлөх, ашиглах</i></p>	
Аюулгүйн гарц, шатыг нээлттэй байлгах, бүх талын хэмнэлтийн дизайнд галын эрсдлийг бүрэн тооцоолсон эсэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, эрчим хүчний нөөцлүүр, хана, дээврийн галын тэсвэртэй байдлыг тооцоолох, сонор сэрэмжийг сайжруулах алхамууд авсан байх - 1 оноо	“Барилга байгууламжийн галын аюулгүйн норм” /БНБД 21-01-02/

Шалгуур үзүүлэлт 5.3 Эдэлгээ өндөртэй материал ашиглалт - 2 оноо

Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга байгууламжийн ашиглалтыг уртасгах, байгалийн нөөцийг хэмнэх, хөрөнгө оруулалт санхүүгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх

Төлөвлөх, барих

Барилгын гол материалуудыг шатамхай байдлын сорилд хамруулсан байх, тэсвэрлэн шатдаг материалын анги тодорхойлох аргын дагуу барилгын материал бүтээгдэхүүнийг галд хариу үйлдэл үзүүлэх байдлын үнэлгээ хийлгэсэн байх 1 оноо

“Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” /БНБД 31-01-10-ийн хавсралт 10-т заасны дагуу эсвэл MNS 4115:91 Барилгын галын аюулгүй байдал. Барилгын материалын ноцох чанар.

Бетон, байгалийн чулуу, тоосго зэрэг галд тэсвэртэй материал ашигласан байх, галын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн байх - 1 оноо

MNS 4244:1994 Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага

Шалгуур үзүүлэлт 5.4 Үерийн хамгаалалт - 2 оноо

Орчны үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугамаар хамгаалагдсан байдал - 1 оноо

Үерийн эрсдэлтэй бүсээс хол байршилтай байх эсвэл нөөц насос, ногоон дээвэр, ногоон хана зэрэг ус шингээх гадаргуу суурилуулсан байх, хийлдэг, эсвэл дэлгэдэг гэх мэт түр зуурын хамгаалалтын хэрэгсэлүүд суурилуулсан байх - 1 оноо

Нийслэлд “Үер, борооны усны байгууламж, usc 0501b:2023 “үерийн хамгаалалт, борооны ус зайлуулалтын байгууламжийн материал, эдлэлийн чанарын шаардлага” - хотын стандарт

Шалгуур үзүүлэлт 5.5 Хур тунадас зайлуулах шугам - 2 оноо

Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгын усан хангамжийг сайжруулах, үерийн гамшгаас давж гарах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх

Төлөвлөх, барих

<p>Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны газар зүйн үзүүлэлт, барилга зам талбайтай уялдуулан талбайн хэмжээнд иж бүрэн шийдвэрлэсэн байх, бетон хаяавчтай байх, ил сувгаар эсвэл газар доогуур шугам хоолойгоор зайлуулсан байх 1 оноо</p>	<p>“Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо цасны ус зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм” /БД 40-302-13/</p>
<p>Хур тунадасны усыг хуримтлуулах, хөрсөнд шингээх арга технологи ашиглах, эсвэл барилга байгууламжийн орчны нэгдсэн усан сан, усны хураагуурт холбосон, эсвэл дренаж суурилуулсан байх 1 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлт 5.6 Барилгын насжилт - 3 оноо</p>	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилгын ашиглалтын хугацааг уртасгаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх</p> <p><i>Төлөвлөх, барих</i></p>	
<p>Зэврэлтээс хамгаалалттай бүтээц, эсвэл зэвэрдэггүй ган, зэс хоолой, бат бэх материал ашиглалт - 2 оноо</p>	
<p>Агаар дахь бодисуудын нөлөөнд бага автах дээвэр, өнгөлгөө ашигласан байх, исэлдэлт, карбонжилтаас хамгаалсан байх - 1 оноо</p>	<p>Орон сууцны барилгын физик элэгдлийг үнэлэх заавар БД 31- 104-01</p>

7.6 Бүлэг 6: Дотоод орчны чанар 6 шалгуур үзүүлэлтт, 12 оноотой

Энэ бүлэгт барилга байгууламжийн дотоод агаарын чанар, үр ашигтай агаар сэлгэлтийн систем, дуу чимээний тусгаарлалт, дуу чимээ, чийгшил, гэрэлтүүлгийн түвшин зэрэг дотоод орчин дахь хэрэглэгчийн эрүүл мэнд, тав тухтай холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан.

Мөн нийтэд хүртээмжтэй барилга төлөвлөлтийг дэмжих зорилготой дотор орчныг хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байлгах үзүүлэлтүүд тусгагдсан болно. Эдгээрийг Хүснэгт 8-д заасан аргачлалын дагуу дүгнэнэ

Заавал биелүүлэх шалгуур үзүүлэлт агаарын чанар 6.1 болно.

Баталгаажуулах аргачлал	Холбогдох норм, дүрэм, стандарт
БҮЛЭГ 6. ДОТООД ОРЧНЫ ЧАНАР	
Шалгуур үзүүлэлт 6.1 Агаарын чанар - 3 оноо (3)	
<p>Шалгуур үзүүлэлтийн зорилго: Барилга, байгууламжийн дотоод агаарын чанарыг сайжруулах, хүний эрүүл мэндийг хамгаалах</p> <p><i>Ашиглах</i></p>	
